



Гэвч дээрх төсөл нь хорих байгууллагуудын захиргааны сэтгэл санааг тайван бус болгон зовоож байна. Хорих байгууллагуудын дарга нарын Үндэсний холбооны үндэсний нарийн бичгийн дарга. Нанта хотын хорих газрын дарга Борис Тарж тайлбарлахдаа: “Хорих газрыг байгуулах санаачлагыг хувь хүнд зөвшөөрсөн тэрхүү арга зүй нь л биднийг гайхшируулж байна”. Хорих байгууллагуудын алба хаагчдын үйлдвэрчний гол эвлэл /UFAP/ мөн 10 сая еврогоор босох туршилтын энэхүү хорих газрын эсрэг саналаа илэрхийлсэн.

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх Холбооны Албаны “Гэмт хэрэг ба ял шийтгэл” сэтгүүлийн 2013 оны №2 дугаараас ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, хурандаа Н.Гантулга орчуулан бэлтгэв



ХСИС-ийн ШШГС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, докторант, хошууч Б.Алтангэрэл

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛЫН ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Нийтлэлийн агуулгын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалд ямар асуудал хамаарах, хөгжлийн чиг баримжааны талаар авч үзэхийг зорилоо. 2011 оноос хойшхи хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик судлал зэрэг нэр томьёо гарч ирэн, түүнчлэн тухайн чиглэлийн магистр, доктор, удирдахуйн ухааны сургалтыг Хууль сахиулахын их сургуульд явуулах болсон, их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн судлал төвийн бүтцийн нэгжийг бий болгон эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын ажлыг явуулах болсон нь туйлын сайшаалтай ажил болсон гэж үздэг юм. Түүнчлэн тус их сургуульд Цагдаа судлал, Хил судлал, Гамшиг судлал, Шүүх шинжилгээ судлал зэрэг салбаруудаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийгдэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалыг зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг судлах, тухайн салбар эрх зүйн судлах зүйл мэтээр ойлгох нь учир дутагдалтай юм.

Я.Цэвэл өөрийн бүтээлдээ Судлал гэдэг нэр томьёог Монгол хэлний утга зүйн хувьд шинжлэл, судлагаа; Судлах гэдэг нь 1. хянаж боловсруулах, хянаж шалгах, 2. сураглах,



ажиглах, турших замаар учир шалтгааныг олж мэдэх, сурч судлах гэж тодорхойлсон байна.

Эрх зүй судлалын хувьд академич, доктор, профессор С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" гэдэг бүтээлдээ Эрх зүй судлал гэдгийг /англи. jurisprudence; legal science; science of law; ор. правоведение/ 1. Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүй судлал; 2. Сургалтын байгууллагын хууль зүйн мэргэжлийн нэр гэж тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал гэдэг нэгдсэн нэг ойлголт одоогоор хараахан үгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал гэдгийг нэр томъёоны болон судлагдахууны хувьд авч үзвэл шүүхээс гаргасан бүх төрлийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны хөгжилт, хэрэгжилт, харьцуулалт, чиг хандлагын тухай судалдаг салбар ухаан юм.

Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал хэзээнээс үүсэлтэй болох, хөгжлийн ямар зам туулсан талаар судлаачид өөрсдийн бүтээлдээ эрх зүйн зохицуулалтын хөгжил талаас нь, тухайн шинжлэх ухааныг судалж ирсэн түүхэн он цагийн дарааллаар нь, Монгол улсад шүүх байгуулагдан шийдвэрээ хэрэгжүүлж ирсэн болон ял шийтгэл ногдуулж ирсэн байдлаар нь зэргээр авч үзсэн байдаг.

Доктор, профессор А.Лхагваа "МУ-ын ШШГЭЗүй" бүтээлдээ 1957-1992 он хүртэл ЗХУ-ын /хуучин нэрээр/ Дотоод явдлын яамны дунд, дээд сургуульд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дунд, дээд мэргэжилтэй, мэргэжсэн хуульчдыг бэлтгэж ирсэн, 1960-аад оны сүүлч үеэс МУИС-ын Хууль зүйн салбар, хуулийн дунд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй" хичээлийг оруулж

тусгай хөтөлбөрөөр зааж эхэлсэн зэрэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинжлэх ухаан хөгжих угтвар нөхцөл болсон гэж салбарын эрдэмтэд үзжээ гэж бичсэн байна.³

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал гэдгийг тодорхойлохын тулд тухайн салбарын судлагдахууны хамрах хүрээний талаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалд дараахь асуудал хамаарч болох юм гэж үзлээ. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбоотой эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн уламжлал судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо судлал

-Ялын бодлого, хэрэгжилт судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дахь гэмт явдал судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох төр, олон нийт, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлагын үйл ажиллагаа судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хүний нөөцийн үйл ажиллагаа судлал

2. Ял эдлүүлэх ажиллагаа судлал

-Ялын төрөл, түүний хэрэгжилт судлал

-Ял эдлүүлэх менежмент, төлөвлөлт судлал

-Ял эдлэгсдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил судлал

³ А.Лхагва "Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй" УБ. 2012 он. 97 дахь тал



-Гэмт хэрэгтэн бие хүн /ялтан/ судлал

3. Иргэний болон Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа судлал

-Иргэний шийдвэр гүйцэтгэл судлал

-Захиргааны шийдвэр гүйцэтгэл судлал

4. Албадлагын арга хэмжээний гүйцэтгэл судлал

-Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ судлал

-Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ судлал

-Хянан харгалзах үйл ажиллагаа судлал

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үеийн аюулгүй байдал судлал

-Аюулгүй байдлын техник хэрэгсэл, барилга байгууламж судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглах техник, хүч хэрэгсэл, галт зэвсэг, тусгай хэрэгсэл судлал

-Ял эдлэгсдэд тавих хяналтын тогтолцоо судлал

-Хорих байгууллагын аюулгүй байдал судлал

6. Гадаад орны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харьцуулсан судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээрхи Олон улсын эрх зүйн эх сурвалж судлал

-Эрх зүйн бүл дэх Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа судлал

-Дэлхийн улс орнуудын шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тактик судлал

-Нийгмийн хямралт байдлын үеийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тактик судлал

-Байгалын хямралт байдлын үеийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тактик судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд бий болсон хямралт байдлын үеийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тактик судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь оргосон этгээд, эд хөрөнгийг эрэн сурвалжлах тактик судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тагнах үйл ажиллагааны тактик судлал

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх тактик судлал

Дээрхи бүлэг асуудлууд нь судлаачын зүгээс хийсэн хуваарилалт бөгөөд нарийвчлан судлахыг та бүхний өмнө нээлттэй орхиж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын судалгааны арга зүйн зарим асуудал

Судалгааны арга /метод-methodos- шинжилгээ, судалгаа, зам гэсэн утгатай грек үг/ нь тодорхой тохиолдол бүрт хэрэглэж буй арга барил, бодит байдлыг онол, практикийн хувьд эзэмших үйл ажиллагаа юм. Судалгааны арга нь шинжлэх ухааны танин мэдэхүйн зам, арга хэрэгсэл болдог. Судалгаа, шинжилгээний аргуудыг философи аргууд, ерөнхий шинжлэх ухааны аргууд, тодорхой шинжлэх ухааны аргууд, судлагдахуун нэг бүрийн аргууд гэж ангилдаг.⁴

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбар хэсгийг судалж буй судлаач нь тохирох аргуудыг сонгож тохируулан, өмнөө тавьсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд судалгааны ажлын аргыг өргөнөөр эзэмшин,

⁴ Ш.Паламдорж, Н.Жалбажав" Судлахуйн үндэс" УБ 2009он.12 дахь тал



тухайн аргын дараалал, горим, технологийг баримталж ажиллах нь зүйтэй юм.

Хууль зүйн шинжлэх ухаанд дараах 3 арга зүйг түгээмэл хэрэглэдэг. Үүнд:

1. Норматив буюу прескриптив
2. Экспликатив буюу дескриптив
3. Харьцуулалт

Норматив арга зүй нь байх ёстой зүйл, хэм хэмжээг чухалчилдаг бөгөөд дараах зарчмуудыг баримталдаг.

1. Метафизик зарчим;
2. Түүхчлэх зарчим;
3. Логикийн зарчим.

Метафизик зарчим нь хүний эрх, эрх чөлөөний ойлголт дан ганц философийн категори, хийсвэр санаа төдий биш энэ нь хэм хэмжээнд суурилах ёстой гэсэн үндэслэлийг чухалчилдаг.

Логикийн зарчим нь хуулийн зүйл, заалт, үзэл баримтлалыг тайлбарлахдаа өөрийн хувийн үзэл бодлоос ангид байдлаар гагцхүү үндсэн хэм хэмжээний агуулгаар тайлбарлахыг гол зорилгоо болгодог.

Дескриптив арга зүй нь дараах зарчмуудыг баримталдаг.

1. Нөхцөл байдлыг шинжлэх зарчим;
2. Онтологийн зарчим;
3. Арга зүйн зарчим.

Нөхцөл байдлыг шинжлэх зарчим нь тухайн цаг үеийн бодит байдлыг судалсны үндсэн дээр үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино. Жишээ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн баталгаа ямар үзүүлэлттэй байна вэ?

2. Хорих ял эдлүүлэх төрөл, дэглэмийн ялгаа?

3. Одоогоор шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зохицуулсан нийт

хэдэн хууль, хуульчилсан акт хүчин төгөлдөр үйлчилик байна ээ? гэх мэт... зэргээр тодорхой арга, арга зүйг судлаачид ашиглах хэрэгтэй юм.

Харьцуулалтын арга зүй нь танин мэдэхүй болон дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэсэн ололт дээр тулгуурлаж байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж буй албан хаагч, судлаачид хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажлыг түлхүү хийж буй нь сайшаалтай хэдий ч үндсэн суурь асуудал болох ялын бодлого, зорилго, үзэл баримтлалыг ажилдаа тодорхойлохгүй дутуу орхих асуудал багагүй гарч байна. Жишээ нь: Хорих ангийн харуул хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж буй судлаачид зөвхөн хорих ангийн харуул хамгаалалтыг зохион байгуулж буй онцлог, техник хэрэгслийг сайжруулах чиглэлээр судалгаа хийн, ялын зорилгыг хангахад харуул хамгаалалтын учир холбогдол, хорих байгууллагад үйлдэгдэж буй гэмт явдалтай тэмцэхэд харуул хамгаалалтын гүйцэтгэх үүрэг, эцсийн үр дүнд харуул хамгаалалтын цаашдын чиг хандлагыг тодорхойлсон, онол, практикийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн дорвитой судалгааны ажил хийх тал дээр учир дутагдалтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хөгжлийн чиг хандлагыг эерэгээр тодорхойлох хүрээнд доорхи саналыг дэвшүүлж байна. Үүнд:

а/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалыг бүх талаас нь хөгжүүлэхэд их